



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



Japan  
Fund for  
Poverty  
Reduction



From  
the People of Japan

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр

Зээлийн дугаар ба нэр: Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах 9192-MON төсөл

Гэрээний дугаар ба нэр: CW-01 дугаартай Зуны болон өвлийн хүлэмж барих

Тендер хүлээн авах эцсийн огноо ба цаг: 2020 оны 2-р сарын 21-ний өдрийн 11 цаг 00 минут

1. Монгол улс Азийн Хөгжлийн Банк (цаашид “АХБ” гэх)-наас Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах 9192-MON төслийг хэрэгжүүлэх зорилгоор зээл авсан ба энэхүү санхүүжилтийн тодорхой хэсгийг дээр дурдсан гэрээнүүдийн хүрээнд хийгдэх төлбөрт ашиглана. Тендер шалгаруулалт нь АХБ-ны эрх бүхий орны<sup>3</sup> харьяат тендер оролцогчдод<sup>2</sup> нээлттэй байна.

2. Тендер оролцогч нь тендерийн баримт бичигт тодорхойлсны дагуу нэг эсхүл хэд хэдэн гэрээний шалгаруулалтад оролцох боломжтой. Нэгээс дээш тооны гэрээ байгуулах эрх олгогдсон тохиолдолд үнийн хөнгөлөлт эдлэх саналтай тендер оролцогчдын хувьд энэхүү үнийн хөнгөлөлтүүд нь Тендер ирүүлэх маягтад тусгагдсан байгаа нөхцөлд энэхүү саналаа гаргаж болно.

3. Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам (цаашид “захиалагч” гэх) эрх бүхий тендер оролцогчдоос CW-01-01 дугаартай зуны хүлэмжүүд барих болон CW-01-02 дугаартай Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 500 м.кв, CW-01-03 дугаартай Увс аймгийн Улаангом суманд 100 м.кв өвлийн хүлэмж барих (цаашид “ажил” гэх) ажлыг барьж гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

4. Энэхүү тендер шалгаруулалтыг АХБ-ны дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтын аргаар явуулна.

5. Зөвхөн доор дурдсан чадварын үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан эрх бүхий тендер оролцогч энэхүү тендер шалгаруулалтад оролцоно:

1. Өвлийн хүлэмжний зураг төслийг гаргаж төсөвтэй нь хамт ирүүлнэ./ Багц-2,3-т хамаатай/

2. Татварын ерөнхий газрын цахим тодорхойлолт /өргүй/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт, Шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа мөн Тендер оролцогчийн талаар харьяа татварын хэлтэс, НД-ын газар, харилцагч банк, шүүх болон бусад байгууллагаас тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай тендер оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ.

3. Тусгай зөвшөөрлийн нотариатаар баталгаажуулсан хуулбар /Багц-2,3-т хамаатай/

4. ГЕН, ГТН болон ажлын даалгаврыг хүлээн зөвшөөрч байгаа тухай албан мэдэгдэл ирүүлнэ.

5. Өвлийн хүлэмжний зураг төслийг гаргаж төсөвтэй нь хамт ирүүлнэ. /Багц-2,3-т хамаатай/

6. Сүүлийн 3 жилд (2016, 2017, 2018 он) гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалтыг ирүүлнэ. Сүүлийн 3 жилд (2016, 2017, 2018 он) гүйцэтгэсэн ижил төстэй барилгын зураг

төсөл болон угсралтын ажил гүйцэтгэсэн нэг гэрээний хуулбар, улсын/техникийн комиссын актуудыг хавсаргаж ирүүлнэ. (Багц 2,3-д хамаатай)

7. Захиалагчийн шаардсан хүлэмжийн техникийн тодорхойлолтын дагуу санал болгож буй хүлэмжийн техникийн үзүүлэлтийг харьцуулан хүснэгтээр бэлтгэж ирүүлнэ.

Багц-2,3:-ын хувьд дараах тусгай зөвшөөрөл шаардлагатай. Үүнд:

- 3.Т 2.1 /1.2.1/ Архитектур,барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ,АГТ, ҮЗБТ)[

- 3.Т 6.1 /1.2.4/: Барилга байгууламжийн дотор усан хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар, шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

- 3.Т 6.2 /1.2.4/: Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн систем, хөргөх байгууламжийн гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

- 3.Т 6.3 /1.2.5/: Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

- БА 2.1 /2.1.2/ Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил

- БА 6.1 /2.2.1/ Барилга байгууламжийн дотор усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

- БА 6.2 /2.2.1/: Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, хөргөх байгууламж тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

- БА 6.3 /2.2.2/ Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

6. Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг дараах хаягаар авч болно.

Байгууллага: Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах 9192-MON төсөл, Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Сайн констракшны байр, 3 давхар, 304 тоот

Харилцах албан тушаалтан: М.Ганпүрэв, Төслийн худалдан авах ажиллагааны мэргэжилтэн

Утас: +976 7012-9192

Цахим шуудан: ganpurev1981@gmail.com

7. Эрх бүхий тендерт оролцогч тендерийн баримт бичгийг худалдан авахыг хүсвэл: Зуны болон өвлийн хүлэмж барих ажил гүйцэтгэх CW-01 дугаартай ажлын тендерийн баримт бичиг авах хүсэлтийг дээр хаягийн дагуу бичгээр ирүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэх нэгжид бэлнээр 50,000 төгрөгийн буцаан үл олгогдох хураамжийг төлж тендерийн баримт бичгийг худалдан авна.

8. Тендерийг дээр дурдсан хаягаар, тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тендерийн баримт бичигт шаардсан тендерийн баталгааны хамт ирүүлнэ. Тендерийг тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссан даруйд тендерт оролцогчдын төлөөллийг (хэрэв тэд оролцохыг хүсвэл) байлцуулан нээнэ.